

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ  
10 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

**НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 10 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

17 дугаар жарны усан туулай жилийн намрын дунд сарын билигт сайн өдөр 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр үндэсний соёл, уламжлалаа хүүхэд залуус, ард иргэддээ таниулах, нутгийн сүсэгтэн зон олноо хүндэтгэн бурхан номын авшиг түгээхээр өвөг дээдсээс уламжлан ирсэн Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошууны хилийн дээсийг эргэж, “Янжив эргэх” уламжлалыг сэргээн, Чойрын Богд хайрхныхаа энгэрт “Жанжин Чойрын Ганжуур эргэх” ёслолыг зохион байгууллаа. “Жанжин чойрын ганжуур эргэх ёслол”-д Зүүн Жанжин Чойрын “Балдан-даш-гомалин хийд, Монголын бурхан шашны төв Гандантэгчилэн хийд, Баянхошууны хийд, Зүүн хүрээ Дашчойлон хийд, Хэнтий, Дундговь аймгийн лам хуврагууд хамтран ажиллалаа.

Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий зэрэг аймгийн 16 сумын өсвөрийн уртын дууч, морин хуурчдын дунд Монгол улсын гавъяат жүжигчин И.Цогбадрахын нэрэмжит “Боржигин морин хуур, Боржигин уртын дуучид” уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд 64 өвлөн уламжлагч, боржигин уртын дууч, боржигин морин хуурчид оролцсон.

Тус арга хэмжээнд нийт 20 байгууллагын 180 албан хаагч, дотоодын 4480 аялагчид оролцсон байна.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2021 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын 1 дүгээр хавсралтыг үндэслэн 7 иргэн, аж ахуй нэгж байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу галын аюулгүй байдлыг шалган илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гурвыг олгож 75.000 төгрөгийг тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд аймгийн хэмжээнд Гал түймрийн зөрчлийн дуудлага 1, хээрийн түймрийн дуудлага 3 дуудлагатай байсан.

Говьсүмбэр аймагт 2023 онд зохион байгуулах Гамшгаас хамгаалах ангиллын сургалт нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Боржигин өв музей, Сум дундын ойн анги, Биеийн тамир, спортын газар, Шүүх шинжилгээний алба, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн сурагчдад нийт 6 удаагийн сургалтаар 491 ажилтан, албан хаагч, сурагчид, иргэдэд Газар хөдлөлт, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал, гамшгийн үед хэрхэн ажиллах тухай анхан шатны ойлголт, галын аюулгүй байдлын тухай ойлголт, гал унтраах дадлага сургууль, “what3words” программын ашиглах талаар 10 цагийн сургалт зохион байгуулж ажилласан байна.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын баталсан “Гэр холооллын “айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж”-ийн хүрээнд Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 5 иргэн, аж ахуй нэгж байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулж 6 зөрчил илрүүлэн 3 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 2 зөрчлийг арилгах талаар заавар зөвлөмж өгч, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 2, танилцуулга 1-ийг тус тус бичиж холбогдох иргэн, аж ахуй нэгж байгуулагад хүргүүлэн ажилласан.

Уг үзлэг шалгалтаар: Сүмбэр Шивээговь сумын 1, 2 дугаар багийн айл өрхөөр галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2852 айл өрхөд зохион байгуулж 1302

зөрчлийг илрүүлэн 182 зөрчлийг газар дээр нь арилгуулж 1120 зөрчил дутагдлыг эргэн шалгах хугацаатай үүрэг чиглэл өгч 1368 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийж ажилласан.

Улсын Онцгой комиссын 01, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 02 албан даалгавар, Аймгийн Засаг даргын баталсан “Намрын нэгдсэн эргүүл шалгалт зохион байгуулах тухай” А/290 дүгээр захирамжийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Онцгой байдлын газрын шуурхай албаны албан хаагчид батлагдсан хуваарь, маршрутын дагуу хээрийн түймэр гарах магадлалтай Сүмбэр сумын 5, 6 дугаар багийн нутгаар 5 өрх, 17 малчин иргэнд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хаврын эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажилласан.

Онцгой байдлын Ерөнхий газар болон Цаг уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 15, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 4, Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай мэдээлэл 9, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээллийг 24 нийт 52 удаагийн мэдээг Онцгой байдлын газрын болон “go.nema.gov.mn” сайтад байршуулж “Чойрын зар”, “Боржигин нутаг минь”, “Шивээговь нэгдсэн зарын групп”, “Говьсүмбэр аймаг” “govisumber.gov.mn”, “Govisumbernews.mn” гэсэн хаягуудад шейрлэж иргэдэд хүргэн ажилласан. “Go.nema.gov.mn” сайтад 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 75456 хандалт хийгдсэн байна.

Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх багц мессежийг 2 удаагийн давтамжтай давхардсан тоогоор 1305 малчин иргэнд хүргэсэн байна.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2023 оны 10 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 9 816 715.2 мянган төгрөг гүйцэтгэлээр 10 425 187 мянган төгрөг буюу 106.2%, үүнээс Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 1 402 469 мянган төгрөг гүйцэтгэлээр 1 604 650 мянган төгрөг буюу 114.5% гүйцэтгэлтэй байна. Сумын төсвийн орлогын төлөвлөгөө 5 985 116,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 6 487 337 мянган төгрөг буюу 108.4%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2 428 810 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2 333 200 мянган төгрөг буюу 96,06%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

### **Статистикийн чиглэлээр:**

Мал төллөлт, төл бойжилтын ХАА-1, Том малын зүй бус хорогдлын ХАА-2 мэдээг 10 багаас, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн ХАА-3, Жимс жимсгэнэ тариалсан талбайн ургац хураалтын ХАА-5, Газар тариалангийн бүтээгдэхүүний ХАА-10 мэдээг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн авч сар бүр Үндэсний статистикийн хороонд дамжуулсан. Аж үйлдвэрийн салбарын АҮ-1, үнийн АҮСҮ-1, Мал эмнэлгийн үйл ажиллагааны МЭ-1, Худалдааны салбарын үнийн ХСҮ, Зочид буудлын үйл ажиллагааны ЗБ-1, Зоогийн газрын үйл ажиллагааны ЗГ-1, Аялал жуулчлалын үйл ажиллагааны АЖ-1а, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ХО-ЗБ мэдээнүүдийг Аж ахуйн нэгж, байгууллагаас хугацаанд нь бүрэн авч Үндэсний статистикийн хороонд дамжуулсан.

Аймгийн 2023 оны 09 сарын Нийгэм эдийн засгийн танилцуулга болон хэвлэлийн бага хурлыг бэлтгэн нийтэлсэн. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн сарын үнэ-21 мэдээг 1 удаа, 7 хоногийн үнийн үнэ-2 мэдээг 4 удаа дамжуулсан. Ажиллах хүчний судалгаа, Ногоон хүчний ажлын байрны судалгааны 30 өрхөөр судалгаанд явсан. Судалгааны тодруулгуудыг тухай бүр тодруулан Үндэсний статистикийн хороонд дамжуулсан. Мөн сар бүр судалгааны явцын хяналтыг тогтмол хийж ажилласан. 3 жил тутам хийгддэг Малын ашиг шим, нэмүү өртгийн судалгаа явагдаж байна. Нийт 99 нэгжээс судалгаа авахаас 90 нэгжээс судалгаа авч 90,9 хувийн биелэлттэй байна.

## **Санхүүгийн хяналт аудитын алба:**

Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 6, нийт 20 байгууллагад хийж 3 011 379.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 12 016.8 мянган төгрөгийг улсын төсвийн орлого болгуулахаар, 14 921.2 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7 100.2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар, нийт 33 486.0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

Актын барагдуулалтын үр дүн 55 хувьтай байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ 2023 оны 1-ээс 7 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтад хяналт хийх мөн 2022 он болон 2023 оны 08 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийж шалгалтын явц 60 хувьтай явагдаж байна.

Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 оны 08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 60 хувьтай.

Дуу бүжгийн Боржигин чуулгын 2022 оноос 2023 оны 07 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийж, тус аудитаар “Дунд” эрсдэлтэй буюу “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгсөн.

Баянтал сумын ЗДТГ-ын хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус дотоод аудит хийсэн. Дотоод аудитаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны түвшиний 50 хувь нь 2-р түвшин буюу “Давтамжтай”, үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 12 асуудлаас 10 нь нөлөө ихтэй буюу “Сайжруулах шаардлагатай” дүгнэлтийг өгч байна. Дотоод аудитаар илэрсэн 12 асуудлын 83 хувь нь удирдан зохион байгуулалт муу байгаагаас үүссэн байна. Иймд цаашид сайжруулж анхаарах шаардлагатай 13, дутагдлыг арилгуулах 30 нийт 43 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг өгч ажилласан.

Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 30 хувьтай. Мөн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж, шалгалтын явц 40 хувьтай байна.

Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, шалгалтын явц 30 хувьтай. Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт 20 хувьтай, Сүмбэр сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалт 10 хувьтай явагдаж байна.

Сум дундын ойн ангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 15 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна. 10 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 93 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 2,4 хувиар буурсан үзүүлэлттэй.

## **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын фейсбүүк хуудас, Хууль Эрх зүйн хэлтсийн фейсбүүк хуудсаар дамжуулан “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Жолоочийн даатгалын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай олон нийтэд сурталчилж мэдээллийг түгээж, Цагдаагийн хэлтэс, багийн Засаг дарга нартай хамтран согтууруулах ундаа худалдан борлуулдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуй нэгжүүдтэй хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж ажиллалаа. /хандалтын тоо-Давхардсан тоогоор 119/

### **Архивын тасаг:**

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 13 хадгаламжийн нэгжийн 1700 хуудас, 271 заалт, 1638 хүний нэр, 271 байгууллагын нэр, 816 газар зүйн нэр, 1700 фотошоф, 1700 скайнер, 1319 холболт хийж ажилласан.

2023 оны 10 дугаар сард 26 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

### Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 187
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 65
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо – 26
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 12
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо- 0
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 3
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 7
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 33
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 15
- Тоон гарын үсэг олголт - 25

**Нийт - 345**

### Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 3
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 8
- Гэрээний бүртгэл - 75
- Барьцааны гэрээний бүртгэл - 199
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 7

**Нийт - 292**

### Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 7
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -7
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл -

**Нийт - 14**

### Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 10
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 0
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 219

**Нийт- 229**

Төрийн үйлчилгээг нийт 880 иргэнд хүргэсэн байна.

## ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД

Тус алба нь хэргийн газрын үзлэг 19, үүнээс хүний амь нас хохирсон 4, хулгайлах гэмт хэрэг 1, зам тээврийн осол 3, бусад 11, Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт 14, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх ажиллагааны 281 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан байна. Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 25 үүнээс Хүнд 1, хөнгөн 11, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 9, гэмтэл тогтоогдоогүй 4. Цогцост хийсэн шинжилгээ 4 байна.

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР

Тайлант хугацаанд нийт 19 хоригдолтой “Нийгмийн ажлын үйлчилгээний гэрээ” байгуулж, “Хорих ял эдлэх үеийн жишиг хөтөлбөр”-ийн дагуу нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Гэм хорын төлбөртэй хоригдлуудаас цалинтай ажлын байраар 3 хоригдол хөдөлмөрт хамрагдаж байгаа бөгөөд ангийн байрлалд үйл ажиллагаа явуулж байгаа “ОСО КОНСТРАКШ” ХХК-ний хөнгөн блок үйлдвэрт ажиллаж байна. Тус 3 хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс 1,138,500 төгрөгийг хохирол төлбөрт шилжүүлэхээр хорих ангийн дансанд байршуулаад байна.

Иргэний цахим үнэмлэхний зөрчилтэй буюу Иргэний үнэмлэхний хүчинтэй хугацаа сунгах (25, 45 нас) 12 хоригдол, хаяж гээгдүүлсэн дахин захиалах 18 хоригдол байна. Үүнээс гадна иргэний цахим үнэмлэхний сунгалт хийх шинээр захиалах 8 хоригдлын хүсэлтийг холбогдох материалын хамт Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

2023 оны 10 дугаар сард нийт 19 хоригдолд “Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг”, “Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэг”, “ШШГТХ-ийн 21 дүгээр бүлэг”, “Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг”, “Хорих ангийн дотоод журам”, “Хяналтын хуудас хэрэглэх журам”, “Аюулгүйн тойрог тогтоох журам”, “Дасан зохицох чадвар суулгах”, “Харилцаанд үүсэх зөрчил”, “Биеэ авч явах байдал”, “Хандлагаа өөрчлөх нь” зэрэг 12 сэдвээр 2 удаагийн давтамжтай нийт 24 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Хоригдлын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор давхардсан тоогоор гитар хөгжмийн дугуйланд 6 хоригдол, бясалгалын сургалтад 35 хоригдол, шагайн харваан дугуйланд 17 хоригдол, шатрын дугуйланд 23 хоригдол, даамны дугуйланд 21 хоригдол, морин хуурын дугуйланд 6 хоригдол, ширээний теннисний дугуйланд 30 хоригдол, Архичид аминчлахуй сургалтад 17 хоригдол, Монгол бичгийн дугуйланд 13 хоригдол, нийт 9 төрлийн сургалт, дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэн 168 хоригдол хамрагдаж байна.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр хорих ангид 212 хоригдол ял эдэлж байгаагаас 153 хоригдлыг хөдөлмөрт хуваарилсан нь нийт 72,8 хувийг ажлын байраар хангаж хөдөлмөрт хамруулсан. Тус хоригдлуудаас хорих ангийн үйлдвэрийн хэсэгт нийт 48 хоригдлыг хөдөлмөрийн дадал олгож мужаан цех, гагнуур, даалин оёх, гөлөм оёх, суран эдлэх хийх, оёдол хийх, гар урлал хийх зэрэг төрлүүдээр хөдөлмөрт хамруулж хүмүүжигч нарын үйлдвэрлэж урласан бүтээлийг арвижуулах, чанаржуулах, олон нийтэд таниулах зорилгоор үзэсгэлэнгийн өрөөг тохижуулан бүтээлүүдийг байршуулсан.

## **ЦАГДААГИЙН ХЭЛТЭС**

Цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2023 оны 10 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 120 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 36, зөрчлийн 84 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 3043 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 107.129.500 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 24 хүнийг эрүүлжүүлж, 23 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 33 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 51 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Сүмбэр сумын нутаг дэвсгэрт найрамдал хотхон, дэнж, төмөр зам, аяганы хонхор, Баянтал сум, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт эргүүлийг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 275 алба хаагч 1670 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн.

Энэ оны 10 дугаар сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, төв, орон нутгийн холбогдох байгууллагаас цахим орчинд нийтлэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

санамж, анхааруулга, зөвлөмж 11, видео шторк 18, бусад 6 нийт 35 мэдээллийг "Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс" пэйж хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд түгээж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан.

Цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, өсөлтийг бууруулах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэл "Private ш дээ-Нууцалъя" нөлөөллийн аян явагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж буй "Та татгалз", "Нууцалъя", "Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт-2023, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхижүүлэх "Эрчимжүүлэлт-2023" арга хэмжээ аянуудын постер, видео бичлэгүүдийг байгууллагын фейж хуудсанд байршуулан олон нийтэд түгээн ажилласан.

Шивээговь сумын ГХУСАЗСЗ хамтран малчдын уулзалтыг зохион байгуулж, тус сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн ахлах ангийн 58 сурагчдын дунд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр "Дэвжээ-2023" тэмцээнд шүүгчээр ажиллаж, аймгийн цагдаагийн хэлтсийн пэйж хуудсанд нэгдэхийг уриалсан.

Аймгийн "Говьсүмбэр телевиз" болон төрийн байгууллагуудтай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд **"БИ СОЁЛТОЙ ЖОЛООЧ"** нөлөөллийн арга хэмжээг, Баянтал, Шивээговь сумын Олон Улсын чанартай босоо тэнхлэгийн авто замд зохион байгуулан ажилласан.

Шивээговь сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Шивээговь сумын Цагдаагийн хэсэг хамтран бага насны хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Шивээговь сумын сургууль цэцэрлэгийн орчмын төв замд 2 ширхэг тээврийн хэрэгслийн хурд сааруулагчийг шинээр байршуулж ажилласан.

## **ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

2023-2024 онд суралцах 5 настай хүүхдийн хамран сурах тойрог, цэцэрлэгийн судалгааг нэгтгэн, хамран сургалт 95%-д хүрсэн.

Боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, энэ хуулийг судлах, боловсролын зорилго, зарчим, тогтолцоо, боловсролын харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад зорилго бүхий сургалтын 7 байгууллагын удирдлага 1, Зөвлөх, тэргүүлэх зэргийн 1 багш, заах аргач зэргийн 2, залуу багш 2, эцэг эх,асран хамгаалагчийн төлөөлөл 1, ажилтан 1 тус бүр оролцсон "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулсан.

Сургалтын байгууллагын менежмент сайжруулах уулзалт, зөвөлгөөнийг боловсролын эрх зүйн шинэчлэлийг сургалтын байгууллагад хэрэгжүүлэх зөвлөмж өгөх, сургалтын байгууллагын менежментийн хэрэгжилт, үр дүн, амжилтын түүхээ хэлэлцэх, сургалтын байгууллагын менежментийг сайжруулахад удирдлага, багш, хүүхдүүд, эцэг эх-асран хамгаалагч, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үр дүн, хамтран ажиллах гэрээ байгуулж байгаа явцтай танилцах, Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургууль, МБСБ хамтран менежментээ сайжруулах, төлөвлөлт хийх зорилгын хүрээнд боловсролын сургалтын 13 байгууллагын удирдлага, багш, ажилтан, эцэг эх нийт 85 төлөөлөл оролцсон.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран СӨБ, ЕБС, МБСБ -ын нийт 83 залуу багш нарыг оролцуулан, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, сурлагын хоцрогдлыг оношлох, хүүхэд бүрийг тэгш сургах арга зүйд суралцах, судалгаанд суурилсан дүн шинжилгээ хийх, төлөвлөлт хийх, чанар үр дүнг сайжруулах арга зүйд суралцах, зөвлөх багш нараас туршлага судлах, 3 дугаар сургууль, цэцэрлэгүүдийн сургалтын байгууллагын менежментээс суралцах, орон нутгийн түүх дурсгалын газартай танилцах аялал, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Аймгийн багш нарын баярын хурал, урлагийн тоглолтыг зохион байгуулж, “Чадварлаг багш” журмын хүрээнд 64 багшийг 19.5 сая төгрөгөөр урамшуулсан.

Багш нарын баярыг угтсан спортын тэмцээнийг 5 төрлөөр зохион байгуулахад 13 сургалтын байгууллага, давхардсан тоогоор 370 багш оролцсон. Тэмцээнийг сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг сургалтын байгууллагаар, шатар, теннис, буухиа тэмцээнийг мэргэжлийн хөгжлийн бүлгээр зохион байгуулснаар олон багшийн оролцоог хангаж ажилласан.

Монгол Улсын хэмжээнд бүс, орон нутаг, нийслэлд тулгамдаж буй асуудлыг шинэлгээр, инновац ашиглан шийдэх санаачилгыг дэмжих "Мон-Х" хөтөлбөрт оролцох хүсэлтэй иргэдэд зориулсан "Мон-Х хөтөлбөр, инноваци" сэдэвт, сургалтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтанд төрийн албан хаагч, иргэд, хувийн хэвшлийн төлөөлөл нийт 84 иргэн хамрагдаж, мэдлэг мэдээлэл авсан.

## **СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Соёл урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран Сүмбэр сумын 5 дугаар багийн нутагт байрлах 2 дурсгалт газарт архелогийн авран хамгаалах судалгааны багийн 11 хүний бүрэлдэхүүнтэй гүйцэтгэж байна.

Хараагүйчүүдийн эрхийг хамгаалах “Дэлхийн цагаан таягтны өдөр”-т зориулж харааны бэрхшээлтэй иргэдийн дунд “АХА” тэмцээн зохиолн байгуулж, сонсдог номын үзэсгэлэн гарган яруу найраг, өгүүллэг, тууж, роман түүхийн сонсдог номоор үйлчилж, шинээр 10 хүнд карт нээж 32 уншигч хамрагдсан.

Соёлын яам болон "JCI Монгол" төрийн бус байгууллагын "Их хүрээ" салбараас хэрэгжүүлж буй "ОЮУНЫ ЭЛЧ-MIND UPDATE" төсөлд Говьсүмбэр аймаг амжилттай оролцож 21 аймгаас шилдгээр шалгарч 2000 ширхэг ном, 10.000.000 сая төгрөгийн номын сангийн тавилга хийлгэх эрхийг авсан.

Боржигин өв музейн танхимын үйлчилгээг нийт 254 үзэгчдэд үзүүлж, явуулын музейн VRBOX-оор тусгай хэрэгцээт 19 иргэнд соёлын үйлчилгээг хүргэсэн.

## **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Залуу хосуудын “ХААН БУГУЙВЧ, ХАТАН СҮЙХ” гэрлэлтийн батламж гардуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулсан. Ёслолын үйл ажиллагаанд Сүмбэр сумын 5 гэр бүл андгай тангараг өргөж, гал голомтоо бадрааж, гэрлэлтийн батламжаа үр хүүхдүүдийн хамт ёслол төгөлдөр гардан авсан.

"ОЛОН УЛСЫН ОХИДЫН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР"-ИЙГ тохиолдуулан Энэ жил - Охидын эрхэд хөрөнгө оруулалт хий "Бидний манлайлал-сайн сайхан байдал" уриан дор нөлөөллийн ажлыг аймгийн Цагдаагийн хэлтэс, Прокурорын газар, Эрүүл мэндийн газар, аймгийн Хүүхдийн зөвлөлтэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан.

Тус үйл ажиллагаанд ЕБС-ийн 1,2,5-р сургуулийн 9-12-р ангийн охид Политехник коллежийн оюутнууд нийт 150 гаруй оюутан, сурагчид хамрагдсан.

## **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Монголын хүүхдийн спортын VII наадмын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын тэмцээн Улаанбаатар хотноо зохион байгуулагдан багийн дүнгээр 2 дугаар байрыг манай аймгийн баг тамирчид хүртэж, цомын эзэн болсон.

Аймгийн хүүхдийн спортын “Бага олимп” -ыг спортын 9 төрлөөр 3-6 насны ангилалаар ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдсан. Энэхүү наадмын хүрээнд “Мөрөөдлийн гоол” футзалын тэмцээн зохион байгуулж, 400 гаруй тамирчид оролцсон.

Оросын холбооны улсын Улаан-Үдэ хотноо зохион байгуулагдсан боксын тэмцээнд Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагч Б.Баяр-Эрдэнэ Монгол улсаа төлөөлөн оролцож, 48 кг жинд Алтан медаль хүртсэн.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР:

Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2022 оны 10 сар	2023 оны 10 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	315	282
Гэрийн төрөлт	2	1
Амьд төрсөн хүүхэд	313	283
Амьгүй төрөлт	3	0
Нас баралт	75	62
Эмнэлгийн нас баралт	20	20
Хоног болоогүй нас баралт	7	5
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	5068	4776
Амбулаторийн үзлэг	108122	101245
Халдварт өвчин	2546	246

Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хамтран “Хүүхдийн хорт хавдрын эрт оношлогоо, зонхилон тохиолдох 6 индекс хавдрын эмнэл зүйн заавар танилцуулах” 3 өдрийн сургалт зохион байгуулж, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч, “Энхбилиг” эмнэлгийн хүүхдийн эмч, өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нийт 5 хүн хамрагдсан.

Эрүүл мэндийн яамнаас үндэсний түвшинд салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, сувилагч, эх баригч мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр нь тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа сувилагч, эх баригчдыг гадаад улсад богино хугацааны сургалтад хамруулсан. Энэхүү ажлын хүрээнд манай орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын 5 мэргэжилтэн БНХАУ, БНСУ-д богино хугацааны сургалтанд хамрагдах шалгуурыг хангаад байна.

Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд алслагдсан орон нутгийн хүн амд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэх цогц үзлэг зохион байгуулах ажлын хүрээнд Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга хамтран гурвалсан гэрээ байгуулан эрүүл мэндийн цогц үзлэг, шинжилгээг зохион байгуулан ажилласан.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Бүгд Найрамдах Солонгос улсын SK Bioscience үйлдвэрийн томуугийн эсрэг 4 цэнт “СКАЙ СЕЛЛ ФЛУ” вакцин авч, 0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, архаг хууч өвчтэй иргэд, 65-аас дээш насны 85 иргэнийг дархлаажуулсан.

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийн үйл ажиллагааг 2023 оны 10 дугаар сарын 10-наас 30-ны өдрүүдэд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж, 2-5 насны хүүхдийг дархлаажуулж, 10 сарын 20-ны өдрийн байдлаар зорилтот бүлгийн 988 иргэд хамрагдан хамралт 55.5 хувьтай явагдаж байна. Мөн 7 болон 15 насны 70 хүүхэд, Политехникийн коллежийн 89 оюутанг товлолын сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан.

Эрүүл мэндийн яам, Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/23 тоот удирдамжаар усан спорт сургалтын төв, төвлөрсөн бус ус хангамжийн 2, нийт 3 газарт төлөвлөгөөт шалгалтыг гүйцэтгэв. Шалгалтын явцад 3 усны дээж авч, хими, нян судлалын үзүүлэлтээр шинжилгээнд хамруулахад лабораторийн дүнгээр “Ундны ус. Эрүүл ахуйн



шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018” стандартад заасан шаардлага хангаж байв.

Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн тамхи, тамхин бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл сунгуулах, шинээр караоке болон хүргэлтийн хоолны үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийн дагуу 4 газрын үйл ажиллагаанд Салбарын хяналтын хэлтсийн даргын баталсан 10-19-02/083/01 тоот удирдамжаар шалгалт хийж, 19 заалт бүхий зөвлөмжийг 2 газарт хүргүүлж, үйл ажиллагааны 2 дүгнэлт гарган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

“Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд Ерөнхий боловсролын 3 сургуулийн 9-12 дугаар ангийн охид болон Политехник коллежийн оюутнуудад “Бэлгийн бойжилт”, “Бэлгийн ариун цэвэр”, “Электрон тамхины хор нөлөө” зэрэг сэдвээр нөлөөллийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, 150 охидыг хамруулсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн цахим бүртгэлийн хэсэгт төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэг нээгдсэн.

Ахмад настныг дэмжих сарын ажлын хүрээнд 78 ахмад настныг урьдчилан сэргийлэх, уламжлалт анагаах ухааны үзлэг шинжилгээнд хамруулж, “Эмийн зохистой хэрэглээ”, “Хийн дасгал, хөдөлгөө”, “Эрүүл зөв хооллолтын ач холбогдол”-ын талаар зөвлөгөө өгч ажилласан.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Ажил олгогч нарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг сурталчилж, шинээр бий болсон 217 ажлын байрыг бүртгэсэн.

- Байнгын шинэ ажлын байр-68
- Түр шинэ ажлын байр-149

39 иргэнийг ажилд зуучлан, мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар бүртгэсэн.

Аймгийн хэмжээнд 238 Аж ахуйн нэгж байгууллагад 4211 албан журмын даатгуулагч бүртгэгдэж, 160 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Үүнд.

- 25-аас дээш ажилтантай – 44 ААНБ-д 119 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- 25-аас доош ажилтантай -194 ААНБ-д 41 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

“Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 144-р зүйл заалтын хэрэгжилтийг хангаагүй 13 төрийн болон орон нутгийн өмчит, аж ахуйн нэгж байгууллагад төлбөл зохих 54450.0 мян төгрөгийг төвлөрүүлэх нэхэмжлэхийг хүргүүлсэн ба нийт 4500.0 мян төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих санд төвлөрүүлсэн.

Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны мод тарих нийтийг хамарсан ажилд 9 сард нийт 48 хүн хүнийг түр ажлын байраар хангаж ажилласан.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээг хамтран хэрэгжүүлж буй Хүнс хөдөө аж ахуйн газарт түр ажлын байраар хангагдан ажиллаж байгаа 3 ахмадын зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавьсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 59 иргэний гэрээний үүргийг хангуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 17937.0 мянган төгрөг төвлөрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг арга хэмжээний хүрээнд 2 иргэнд 16.0 сая төгрөг, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг арга хэмжээний хүрээнд 6 ахмадад 30.0 сая төгрөг, Иргэн аж ахуйг дэмжих санхүүгийн дэмжлэг арга хэмжээний хүрээнд 4 иргэнд 35.0 сая төгрөг, Малжуулах арга хэмжээний хүрээнд 2 өрхөд 10.0 сая төгрөг олгохоор тус тус шийдвэрлэсэн.

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:**

2023 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг нийт 12489 иргэнд үйлчилсэн. Аймгийн хэмжээнд амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, 24 иргэний асуудлыг хэлэлцэж, зорилтот бүлгийн иргэдэд тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг үзүүлсэн. 2023 оны 10 сарын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 42 өрхийн 216 гишүүнд олгохоор олголт үүсгэсэн. [www.Ehalami.mn](http://www.Ehalami.mn) системээр дамжуулан иргэдийн үйлчилгээг бүртгэн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 637 иргэний, жирэмсэн эхийн тэтгэмжид 103 иргэний тэтгэмжийг илгээсэн.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж 10 сард 7129 хүүхдийн олголтыг үүсгэж илгээсэн. 2023 оны 10 сарын 20-ны байдлаар ахмадын хөнгөлөлт тусламжийг 34 иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг 57 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 1 удаа зохион байгуулж, 3 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байнгын асаргаанд байх шаардлагатай хугацааг сунгах, 1 хүүхдийг цуцлах, 3 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоон шийдвэрийг гарган ажилласан.

№	Үзүүлэлт	2023.01.01 2023.10.20
		Хүн тоо
1	Халамжийн тэтгэвэр	280
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	254
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	242
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	960
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	116
6	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	142
7	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	
8	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1458
9	Цалинтай ээж	701
10	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	280
11	Насны хишиг	743
12	Өрх толойлсон эх, эцгийн тэтгэмж	42
13	Ихэр хүүхдийн тэтгэмж	3
14	Олон нийтийн оролцоонд түшиглэлэсэн халамжийн үйлчилгээ	84
15	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	7176
<b>Нийгмийн халамжийн сангийн дүн</b>		<b>12489</b>

Хөтөлбөрийн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж, залуучуудыг ажилтай орлоготой болгоход дэмжлэг үзүүлсэн байна.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

#### **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2022, 2023 онд олгосон нийт 85 хүлэмжийн ашиглалтыг тооцоход Баянтал сум 78%, Шивээговь сум 60%, Сүмбэр сум 60% -ийн ашиглалттай байна.

Аймгийн дүнгээр нийт 543.28 тн ургац хурааснаас төмс 167.14 тн, хүнсний ногоо 272.14 тн, ногоон тэжээл 104.0 тн байна. Ургац хураалт дууссан. “Намрын ногоон өдрүүд-2023” улсын үзэсгэлэн худалдаанд нийт 5 аж ахуйн нэгж оролцож, 2 аж ахуйн нэгж шагналт байранд шалгарсан.

#### **МАЛ АЖ АХУЙН ХАВАРЖИЛТЫН ТАЛААР:**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/216 дугаар захирамж, 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөө гарсан.

Малчдын түвшинд 10 дугаар сарын 15-ны байдлаар бэлтгэсэн өвс 6168 тн, үйлдвэрийн тэжээл 949 тн, гар тэжээл 93 тн, хужир 465 тн, өвс, тэжээлийн бэлтгэл хангалт 65 хувьтай байна.

Говьсүмбэр аймгийн малчдын түвшинд бэлтгэсэн байдал

Сумын нэр	Шаардагдах тэжээл /тн/				Тэжээлийн нэгжид шилжүүлснээр	Бэлтгэсэн тэжээл /тн/				Малчдын түвшинд тэжээл бэлтгэлийн хувь
	Бүдүүн			Эрдэс		Бүдүүн			Эрдэс	
	Өвс	Үйлдвэрийн тэжээл	Гар тэжээл	Давс, хужир, шүү		Өвс	Үйлдвэрийн тэжээл	Гар тэжээл	Давс, хужир, шүү	
Баянтал	1591	265	16	104	739	520	4.0	2.0	3.0	<b>32.5</b>
Сүмбэр	7455	1243	75	466	4705	5200	945	91	460	<b>73.5</b>
Шивээговь	1199	200	12	73	556	448	0	0	2	<b>36.3</b>
<b>Нийт</b>	<b>10245</b>	<b>1708</b>	<b>102</b>	<b>644</b>	<b>4758</b>	<b>6168</b>	<b>949</b>	<b>93</b>	<b>465</b>	<b>65.0</b>

Засгийн газрын тусгай хэрэгцээний Малх отрын бүсийн бэлчээрийн даацын судалгаагаар 89.2 мян.толгой мал өвөлжих боломжтой судалгаа гарсан. Орон тооны бус зөвлөлийн хурлыг 2023 оны 10 дугаар сарын 21-нд зохион байгуулж Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас 75.2 мян.толгой мал, Төв аймгийн Баянжаргалан сумаас 14.0 мян.толгой малыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ээс 2024 оны 04 дүгээр сарын 01 хүртэлх хугацаанд оруулахаар шийдвэрлэсэн.

Баталгаажсан үүлдэр, омгийн малд цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгчээр хангах замаар бог малын чанарыг богино хугацаанд сайжруулах зорилгоор Барга үүлдрийн 20 толгой хээлтүүлэгчийг худалдан авч малчдад гэрээгээр ашиглуулах ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Мал аж ахуйн сэргэлт” Залуу малчдын үндэсний чуулганд 21 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Улсын аварга малчин Ц.Энхжаргал “Малчин 100 мэргэжлийн эзэн”, Тэшийн ус хоршооны дарга М.Мөнхзаяа “Малын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж, миний туршлага” гэсэн сэдвээр ХХААХҮЯ-ны урилгаар илтгэл тавьсан. Залуу малчид тулгамдаж байгаа асуудлын талаар өөрсдийн үзэл болдоо илэрхийлж оролцсон.

### ХОРШОО, ЖДҮ, АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Ахуйн үйлчилгээний салбар, оёдол, хими цэвэрлэгээ тэр дундаа гуталчдын үйл ажиллагааг сурталчлах, дэмжих, менежментыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, туршлага судлах арга хэмжээг 10 дугаар сарын 04-өөс 07 нд зохион байгуулсан.

Арга хэмжээнд 16 ахуй үйлчилгээ эрхлэгч, мэргэжилтэн оролцож, Улаанбаатар хотод “SHOES LOVE” ХХК, СИ ЭС ЭЛ ХХК-ийн гутлын үйлдвэр, түүхий эд материалын үйлдвэр хими цэвэрлэгээ, Баянхонгор аймгийн “Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК зэрэг 4 аж ахуйн нэгж байгууллага, Ахуй үйлчилгээний төвүүдтэй танилцсан.

Оёдол эсгүүр, Хими цэвэрлэгээ, гутал засвар үйлчилгээ, шинээр гаргаж буй гутал арчилгааны бүтээгдэхүүн, сав баглаа боодол, нэрийн дэлгүүр, дэвшилтэд тоног төхөөрөмжүүд, хивс угаалга, борлуулалтын цэгүүд, үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж сургалт, зөвлөгөө мэдээлэл авч хамтран ажиллах санал гарган туршлага судалсан. Аймгийн засаг дарга, Сүмбэр сумын засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран орон нутгийн ахуй үйлчилгээ эрхлэгч 30 иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөлтэй уулзаж арга хэмжээний үр дүнг хэлэлцэн өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлаар санал солилцсон.

### ХҮНСНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

Хүнсний нөөцийн бодит мэдээллийг 3 сумаас авч нэгтгэв. Үүнд: Аймгийн дүнгээр мах 7.53 тн буюу 5, гурил 37.12 тн буюу 27, сүү 2.62 тн буюу 1, төрөл бүрийн будаа 13.63 тн буюу 20, төмс 7.5 тн буюу 4, хүнсний ногоо 8.1 тн буюу 2, элсэн чихэр 2.39 тн буюу 5, давс 1.72 тн буюу 6, савласан ус 24.06 тн буюу 1, өндөг 7.1 тн буюу 26, ургамлын тос 3.32 тн буюу 11 хоногийн нөөцтэй байна.

№	Хүнсний нэр төрөл	Сүмбэр			Баянтал		Шивээговь	
		Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц
1	Малын мах	тн	7.53	6	0	0		
2	Гурил	тн	37.1	37	0.02	0		
3	Гурилан бүтээгдэхүүн	тн	2.26	1	0.08	0		
4	Төрөл бүрийн будаа	тн	13.6	27	0.026	1		
5	Сүү	тн	2.6	2	0.02	0		
6	Өндөг	тн	7.1	35	0.0033	0		
7	Ургамлын тос	тн	3.3	14	0.015	1		
8	Төмс	тн	4.5	6	0	0		
9	Хүнсний ногоо	тн	3.8	3	1.3	5		
10	Элсэн чихэр	тн	2.06	6	0.332	11		
11	Давс	тн	1.7	8	0.023	1		
12	Савласан цэвэр ус	тн	23	2	1.055	1		

Төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний Аймгийн үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2023 оны 10 дугаар сарын үнийн мэдээ.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй хонь, үхрийн мах 500 төгрөгөөр, төмс 200 төгрөгөөр, хүнсний ногоо 50-200 төгрөгөөр, гурил 800 төгрөгөөр өссөн бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 1060 төгрөгөөр, цагаан будаа 533 төгрөгөөр, ургамлын тос 2390 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2023 оны 10 дугаар сарын 19-ний байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сараас 6.2-11 хувиар өссөн байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ	Доод үнэ	Өссөн
---	--------------------	----------	----------	-------

			төг	төг	буурсан
1	Үхрийн мах	Ястай	13000	10000	
		Цул	16000	14000	1000
2	Хонины мах	Ястай	10000	7500	
		Цул	13000	10000	1000
3	Адууны мах	Ястай	10000	8000	
		Цул	11000	8500	
4	Ямааны мах	Ястай	8000	7000	
		цул	11000	8500	
5	Тахианы мах	Гуя	14000	9600	
		мөч	12000	9400	1000
6	Лууван	монгол	2500	1800	300
		хятад			
7	Төмс	монгол	2500	1400	700
		хятад			
8	Байцаа	монгол	1800	700	
		хятад			
9	Чинжүү	монгол	9800	6000	300
		хятад	5800	4500	
10	Манжин	монгол	2500	1000	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2900	2200	500
		Хятад	2350		
12	Помидор	монгол	10000	4000	1200
13	Өргөст хэмх	монгол	9200	5000	
14	Элсэн чихэр		4800	3800	100
15	Будаа	Цагаан задгай кг	4300	3200	500
		Шар слава кг	5100	5050	
		Гурвалжин будаа кг	7950	3900	
16	Сүү	Задгай	3000	2500	200
		Сүү ХХК 0,5л	2600		300
		Сүү ХХК 1л	5600	4800	700
17	Тараг	Задгай	3000	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4550	4250	200
18	Талх	Чойр талх	3800	-	1500
19	Өндөг	ОХУ	700		300
		Монгол	580	500	
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	2800	2700	
		Задгай 1-р зэрэг	2900	2350	
		Задгай 2-р зэрэг			
		Савласан д/дээд /			
		Савласан дээд	2560		
		Савласан 1-р зэрэг	2520		
		Савласан 2-р зэрэг			
21	Ургамлын тос	Олейна	8400		
		Алтан	5800		
22	Гоймон	Алейка			

	Лапша	4700		
--	-------	------	--	--

## **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ,**

### **ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОХИРДОЛ, ГАЗРЫН АСУУДЛЫН ХҮРЭЭНД:**

Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран хэрэгжүүлж буй "Монгол улсад аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд аюултай хог хаягдлын шинжилгээний болон хүний нөөцийн чадавхыг сайжруулах" төслийн хүрээнд "Монгол улс дахь аюултай хог хаягдлын менежментийн өнөөгийн байдал ба гадаад улс орнуудын туршлага" семинар 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгчид оролцсон.

Аймгийн Засаг даргын "Нэгдсэн эргүүл шалгалт, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах тухай" 2023 оны А/290 дүгээр захирамжийн дагуу байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл хяналт шалгалт, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх зорилгоор Тэрэгт, Бүдүүн, Их бага уул, Банзарын хоолой, Хөөт, Гүнжийн хоолой, Сайн ус, Дулаан, Чойр гэсэн маршрутаар нийт 200 км эргүүл, хяналт шалгалт хийсэн. Эргүүл, хяналт шалгалтаар 5 өрх, 17 хүнд гарын авлага тарааж, үлээгч аппарат бүхий бүлгийн 3 өрхөөр орж ажилласан

Ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллежийн Олон улсын Эко сургуулийн шалгуурыг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, Ерөнхий боловсролын сургуулиудын тогтвортой хөгжлийн боловсрол олгох хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагааг олон нийтэд түгээн сурталчлах, байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлаа багасгах, ангилан ялгах мэдлэг ойлголтыг өгч, зөв дадал хэвшлийг бий болгоход уриалах, байгальд ээлтэй амьдрах нөлөөллийн арга хэмжээг 2023 оны 3 сараас эхлэн үе шаттай үйл ажиллагаа зохион байгуулж, тайлант өдөрлөгийг 2023 оны 10 сарын 12-нд зохон байгуулав. Тус арга хэмжээнд "Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй" аяны тайлант өдөрлөг, хог хаягдлаар хийсэн бүтээлийн үзэсгэлэн, Дахивар авах үйл ажиллагаа, Мод бутны үзэсгэлэн худалдаа, сургалтад нийт 14 байгууллага, 410 хүн хамрагдсан.

2023 оны турш зохион байгуулсан байгаль хамгаалах, хог хаягдлыг бууруулах, хог хаягдлаар бүтээл хийх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох, Олон улсын эко ногоон сургууль хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх ажиллагаанд идэвхитэй оролцож манлайлсан сургуулийг шалгаруулж урамшуулсан.

Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, "Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй", "Жорлонгоо өөрчилъе" аяныг идэвхижүүлэх хүрээнд иргэд олон нийтэд хог хаягдлаа багасгах, ангилан ялгах мэдлэг ойлголтыг өгч эерэг дадал хэвшлийг бий болгоход уриалах, хөрс бохирдуулахгүй, байгальд ээлтэй, шинэлэг технологи бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ сурталчилах, мэдээлэл өгөх зорилгоор ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ өдөрлөг, ДАЯС -дахивар үйл ажиллагааг "Хоггүй монгол" ТББ, "Төвшин сайхан" ТББ нартай хамтран зохион байгуулсан. Дахиварт нийт 160 гаруй хүн 5 тн хуванцар, 3100 шил, 350 кг гялгар уут, 500 кг цаас, 112 ш хаягдал зай дахиварт тушаасан. Дахивар авчирч өгсөн хүмүүст Хоггүй монгол ТББ-аас гарын бэлэг, ариун цэврийн цаас, эдийн савангаар урамшуулсан.

### **БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УСНЫ АСУУДЛЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн 2023 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 19.9 сая төгрөгийн хөрөнгөөр уруйн үерийн улмаас 2022-2023 онд эвдрэлд орсон Сүмбэр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Цоорхойн рашаан, Уулзварын гол, Асгана булгийн хамгаалалтын хашааг сэргээн засварлах ажлыг "Жавхлант Аривжих" ХХК, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 7.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр

сумын 5 дугаар багт байрлах Хөндлөн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг тухайн булгийн ойролцоо нутагладаг “Хүхээгийн гол” малчдын бүлэг хийж гүйцэтгэсэн.

## **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР:**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/262 дугаар захирамжаар удаашралтай барилга байгууламжийн ажлуудад очиж ашиглалтад ороход хүндрэлтэй байгаа асуудал, шалтгааныг тодорхойлох, шаардлагатай арга хэмжээг шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр барилга угсралт, тохижилтын 8 байршилд газар дээр нь очиж ажилласан.

Мөн 2023 оны 10 дугаар сарын 04 болон 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд барилга угсралтын 4 компанитай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсгийн дүгнэлт зөвлөмжийг гаргаж ажилласан.

Геодезийн байнгын хатуу цэг тэмдэгтийн тооллогын ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ажлын хэсэг байгуулж ажлыг 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр нийт 61 цэг тэмдэгтийн бүртгэл байгаа ба үүнээс шаардлагатай 11 цэгт тооллого бүртгэл хийж ажилласан.

## **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС:**

**Шивээговь сумын 3-р цэцэрлэг 150 хүүхдийн өргөтгөлийн барилга:** 1-р давхарын гадна дотор хана өрөгдөж дууссан. Гадна хана парпедны хэсэг, 2-р давхарын гадна ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Барилгын өрлөгийн ажлын гүйцэтгэл 85 хувьтай, нийт ажлын гүйцэтгэл 63 хувьтай үргэлжилж байна.

**Аймгийн төвийн 2000м<sup>3</sup> цэвэрлэх байгууламжийн ажил:** Захиргаа аж ахуйн барилгын ажил 1,2 дугаар давхарын төмөр бетон каркасын ажил бүрэн хийгдэж дууссан. Биоректорын барилгын цутгамал хийцлэл мөн дууссан гүйцэтгэгч улирлаас хамааралтай барилгын ажлыг түр зогсоож талбайгаас буусан.

**Халуун усны барилга:** Барилгын гадна хана бүрэн өрөгдөж дууссан, дотор хана 85 хувийн гүйцэтгэлтэй, өрлөгийн шавардлагын ажил үргэлжилж байна. Талбайд 4 хүний бүрэлдхүүнтэй бригад ажиллаж нийт ажлын гүйцэтгэл 63 хувьтай. Ажлыг яаравчлах хүйтний улирлаас хамааралтай гүйцэтгэх ажлын дарааллыг оновчтой сонгож гүйцэтгэх чиглэл өгсөн.

**Аймгийн төвийн 2,8км авто замын ажил:** Авто замын ажлын гүйцэтгэл 75 хувьтай. Асфальтан зам талбайн хучилтын ажил бүрэн дууссан. Хэвтээ босоо тэмдэглэгээ ус зайлуулах хоолой, гэрэлтүүлгийн ажил, хавтан зам талбайн хучилт ажил үргэлжилж байна.

**Худалдаачны гудамжны тохижилт:** Дугуйн замын далангын үе бүрэн хийгдэж дууссан дугуйн замын хашлага суулгах ажил, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 45 хувьтай

**0,36км автозамын ажил:** Нийт ажлын гүйцэтгэл 85 хувьтай. Дугуйн зам явган замын ажил 55 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Трассын дагуу шугам сүлжээний давхцал гарсан тул ажил удааширсан.

**Боржигон чуулгын барилга:** Барилгын ажлын гүйцэтгэл нийт гүйцэтгэл 60 хувьтай барилгын цонх суулгасан, металл фасадны захиалага хийгдэж 11 дүгээр сарын эхээр барилгын талбайд буух төлөвлөгөөтэй байна. Барилгын талбайд дотор хамар хана шаврын ажил хийгдэж байна. 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан ээврийн ажил техникийн давхарын угсралтын ажлыг хийж гүйцэтгэхээр гүйцэтгэгч компани төлөвлөн ажиллаж байна.

**Орон нутгийн өмчийн газруудын засвар:** 4 дүгээр сургуулийн дээвэр засварын ажил 70 хувьтай, аймгийн Засаг даргын Тамгын газрын засвар буулгалтын ажил эхэлж 10 хувьтай. Татварын хэлтсийн барилга 10 хувьтай. Байгаль орчин аялал жуулчлалын газрын барилгын

засвар 60 хувьтай засварын ажил хийгдэж байна. Бараа материал таталт 80 хувьтай талбайд буусан.

### **ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТАЛААР:**

Хяналтын тооллогыг 2023 оны хагас жилийн дүнгээр явуулахаар удирдамжид тусгасан боловч байгууллагын удирдлага, нягтлан бодогч солигдож хагас жилийн тооллого хийгдээгүй байх тул 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр хяналтын тооллого явуулж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалтай танилцах, тогтоол шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж байгаа эсэхийг тогтоож, зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Орон нутгийн өмчит байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой 7 асуудлыг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулахаар материалыг хүргүүлсэн. 2023 оны түрээсийн орлого 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 30.6 сая төгрөг байна.

### **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА:**

Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааны явц:

Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 онд нийт 8.279.947.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс нэг ч тендер шалгаруулалт зарлаагүй байна. Худалдан авах ажиллагааны явц 70 хувьтай.

Үйл ажиллагааны явцад төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй. Төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4.194.800.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- Үнэлгээ хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 1 / 85.000.0 мянган төгрөг/
- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ -1 / 4.109.800.0 мянган төгрөг/ Төлөвлөгөөний биелэлт 50 хувь.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1.023.869.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга 1/ 50.000.0 мянган төгрөг/
- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 6 / 973.869.4 мянган төгрөг/ Төлөвлөгөөний биелэлт 90 хувь.

Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2.451.959.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс:

- Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга хэмжээ – 2 / 781.819.1 мянган төгрөг/
- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 10 / 1.670.140.0 мянган төгрөг/ Төлөвлөгөөний биелэлт 80 хувь.

Аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440.616.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 440.616.5 мянган төгрөг, Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

Аймгийн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 28.702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 28.702.0 мянган төгрөг Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

Аймгийн “Бусад хөрөнгө оруулалт”-аар 28.702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 100.000.0 мянган төгрөг Төлөвлөгөөний биелэлт 60 хувь



Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан - 13
- Харьцуулалтын аргаар - 9
- Зөвлөх үйлчилгээний тендер – 4 байна.

### **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР**

Говьсүмбэр аймаг дахь ХУРДАН цэгүүдээс 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд 646 төрийн үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэж, цахим үйлчилгээ болон e-mongolia гар утасны аппликейшний талаар 301 зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Төрөөс үзүүлж байгаа цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажлын хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн “Төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах уулзалт сургалт”-ыг зохион байгуулж, 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 26 байгууллагын 273 төрийн албан хаагчдад сургалт уулзалтын ажлыг зохион байгуулсан байна.

2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Цахим хөгжил, харилцааны холбооны яамны бодлого үйл ажиллагааг сурталчлах, “ЦАХИМ АЙМАГ” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох сургалтын үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, аймгийн 150 төрийн албан хаагч хамрагдлаа. [Huduu.mn](http://Huduu.mn) сайтад 9 цэсэд нийт 51 төрлийн мэдээлэл оруулан өдөр тутам аймгийн хэмжээнд болсон шинэ мэдээнүүд болон ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг оруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 21 аймгаас хамгийн их хандалттай буюу 933 хүний хандалттай байна.

### **ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:**

Орон нутгийн 15 нэр төрлийн татварын орлого бүрдүүлэхээс 10 дугаар сарын байдлаар 11 төрлийн татварын орлого бүрдээд байна. Орон нутгийн татварын орлого гүйцэтгэлээр 1 628 186.8 мянган төгрөг бүрдсэн.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсэг 14 хоног тутамд албан байгууллагууд болон аж ахуйн нэгжээр хяналт хийж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Сумын дулааныг хангах байгууллага болох “Илчлэг Шивээ” орон нутгийн өмчит аж ахуйт тооцоот үйлдвэрийн газар өвөлжилтийн бэлтгэл ажил 100%-тай хангагдсан. Бусад албан байгууллага, аж ахуйн нэгжийн өвөлжилтийн бэлтгэл ажил үе шаттайгаар явагдаж 90-с дээш хувьтай байна. Мөн сумын аюулгүйн нөөцийг 1000 боодол өвсөөр бүрдүүлж ажилласан.

Мөн сумын Засаг даргын А/77 дугаар захирамжийн дагуу “Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил”-ын нийлүүлэгч сонгон шалгаруулж, гэрээг байгуулсан. Тус ажил нь 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн гүйцэтгэгдэж эхлээд байна.

Сумын 2023 оны Орон нутгийн хөгжил сангаар хийгдэх “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх” ГСАШГСЗДТГ/202304011 дугаартай ажлын тендерийг зарлан, гүйцэтгэгчийг шалгаруулж, 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ажил хийгдэж эхлэсэн. 2023 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар тус ажлын гүйцэтгэл 100%-тай гүйцэтгэгдэж, ажлын хэсэг тус ажлыг хүлээж авсан.

### **СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:**

Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг 367 иргэнд хүргэсэн бөгөөд оршин суугаа хаягийн тодорхойлолтыг 210 иргэнд олгож, бусад үйлчилгээгээр 157 иргэнд үйлчилсэн.

2023 оны 10 дугаар сарын 13-ны байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 4 051.7 сая.төгрөг, гүйцэтгэл 4 556.8 сая.төгрөг буюу 112.5% хувьтай, орон нутгийн авлага 6 860.0 мянган төгрөг, өглөг 20 029.6 мянган төгрөг байна.

Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 2023-2024 оны Өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах тухай А/01 дугаар албан даалгаврын хүрээнд малчдын түвшинд 2600 тн өвс, 30 тн ногоон тэжээл, 179 тн үйлдвэрийн тэжээл, 65 тн гар тэжээл, 316 тн давс, хужир, шүү бэлтгэсэн.

### **БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:**

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй "Энэ жилдээ эрүүл жиндээ", "Цаг гаргая" аяны хэрэгжилтийн хүрээнд Монголын явган алхалтын холбоо, Ахмад явган аялагч ахлагч клуб, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран "Чойрын Богд уулын гороо алхалт" буюу 50 км-н алхалтыг 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Алхалтад Увс, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Багахангай дүүрэг, Улаанбаатар хотоос нийт 60 алхагч оролцож 50 км замыг туулсан. Хамгийн залуу алхагч 22 настай, хамгийн ахмад алхагч 74 настай байлаа. Алхалтыг спортын мастер Б.Даваахүү удирдаж, чиглүүлэгчээр Соёлын төвийн дарга Х.Энхжаргал ажилласан. Энэхүү арга хэмжээнд спортын мастер 2, олон улсын алхагч цолтон ( хүрэл медальтан) 10 оролцсон байна.

Ургац хураалтын ажил дуусч 1.02 га талбайгаас 8.5 тн төмс, 2.074 га талбайгаас 19.2 тн хүнсний ногоо, 0.4 га талбайгаас 0.4 тн тэжээл, нийт 3.49 га талбайгаас 28.1 тн ургац хуран авсан дүнтэй байна.

Энэ онд шинээр 5 хүлэмж иргэдэд олгон нийт 19 иргэн хүнсний 3 төрлийн ногоог 1163 м2 талбайд тариалж 3.8 тн ургац хураан авсан.

Хоёр малчин Төв, Хэнтий аймагт хадланд гарч одоогийн байдлаар 20 тн байгалийн хадлан бэлтгэсэн. Малчин өрхийн түвшинд 1.7 тн үйлдвэрийн тэжээл худалдан авч нөөцөлсөн.

### **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**